



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/34

Модот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дүгээр зүйлийн 33.1.1 дэх заалтууд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 24 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэхээр тусгагдсан Цэнхэрмандал сум, 4 дүгээр баг Баянмод, Хайлааст хаягт байрлах, 4993444 төлөвлөлтийн нэгж талбарын

дугаартай, хүний хөгжлийн ордон барих, 614 квадрат метр газрыг Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газар (9074783)-т 30 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар эзэмших эрхээ хэрэгжүүлж, эзэмшиж авсан газраа хуулийн дагуу кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3.Газар эзэмшигчид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэх, газрын ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ